



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 2/143

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 210 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн а/130 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар"-ын 2.4 дэх хэсгийн "5-аас доошгүй хоногийн өмнө" гэснийг "3/гурав/-аас доошгүй хоногийн өмнө" гэж, мөн зааврын 2.3 дахь хэсгийг "2.3.Хуулийн этгээд энэ зааврын 2.2-т заасан бүртгэлийн кодоор өргөдлийн дугаар олгох цахим системд нэвтэрч өргөдлийн цахим дугаар авах бөгөөд өргөдлийн бүртгэлийн эхний 600 цахим дугаар авсан хуулийн этгээдэд өргөдөл гаргах огноо /өдөр, цаг, минут/-г өргөдлийн бүртгэлийн цахим системээр мэдэгдэнэ" гэж, мөн зааврын 3.1 дэх хэсгийн "харгалзан өргөдлийн" гэснийг "харгалзан энэ зааврын 2.3 дахь хэсэгт заасны дагуу өргөдлийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалаар "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар"-т оруулсан нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын цахим хуудсаар нийтэд мэдээлж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Терийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЦОГТ



10 0962